

Хүүхдэд зориулсан Библи
танилцуулж байна



Хан хүү
хоньчин
болсон нь



Зохиогч: Edward Hughes

Зураглаач: M. Maillot; Lazarus

Найруулсан: E. Frischbutter; Sarah S.

Орчуулсан: Damdin Norolsuren

Бүтээсэн: Bible for Children
www.M1914.org

©2014 Bible for Children, Inc.

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.**



Нэгэн өдөр Мосе нэгэн Египет хүн Еврей боолоо зодож байхыг харав. Мосе хэдийгээр Фараоны ордонд өсөж Ханхүүгийн адилаар өссөн ч тэр Еврей хүн байв. Тэрээр зодуулж буй боолд туслав.



Мосе эргэн тойронд хүн харж байгаа эсэхийг ажаад боолоо зодож байсан Эзэн уруу нь дайрав. Тэд зодолдож Мосе тэр Египет хүнийг алав. Тэрээр түүнийг тэр даруй нууцаар оршуулжээ.



Дараа өдөр нь Мосе хоёр Еврей хүн хоорондоо зодолдож байхыг харав. Тэр тэднийг болиулахыг хичээв. Гэтэл тэдний нэг нь "Чи өчигдөр алсан Египет хүн шиг биднийг өнөөдөр алах гээ юү?" гэв. Мосе айдаст автжээ.



Түүний хийсэн хэрэг илэрчээ. Фараон ч энэ тухай мэдсэн байв. Мосе зугтаах хэрэгтэй байлаа. Тэрээр тэндээс зугтан Мидиан гэдэг нутагт иржээ.



Тэнд Мосе нэгэн худгийн дэргэд суугаад амарч байв, гэтэл Мидианы тахилчийн долоон охин хонин сүргээ услахаар худагруу ирэв.



**Бусад хоньчид бас сүргээ услахаар ирсэн бөгөөд тэд
охидыг худгаас хөөв. Мосе охидод тусалж бас бусад
хоньчдоос
хамгаалав.**



"Та нар яагаад эрт ирэв!"
гэж охидын эцэг болох Реуел
охидоосоо асуув. Охид болсон
явдлыг эцэгтээ хэлтэл
"Түүнийг дагуулан ир"
гэв. Ингээд Мосе
Реуелын гэрт
амьдрах болов.

Удалгүй Мосе
Реуелын том
охинтой гэрлэв.




Түүнийг Египетэд буцаж
ирэхэд Фараон нас барсан
байв. Бурханы ард түмэн
болох Египетчүүд



боолчлогдсон
хэвээрээ байлаа.



Тэд хэрхэн зовж хэрхэн
Бурханаас тусламж гуйн
хашхирсан болоо! Бурхан
тэдний залбирлыг сонссон
ЮМ.



Бурхан түүнийг Еврей ард түмнийг
боолчлолоос чөлөөлүүлэхээр
төлөвлөсөн байсныг Мосе мэдээгүй
байлаа. Мосе Египетээс гарснаас
хойш дөчин жил өнгөрчээ. Тэр
энэ хугацаанд Реуелын хонийг
хариулж байв. Гэвч тэр
Египетэд байсан өөрийн


хүмүүсээ маш
их санаж байлаа.




Нэгэн өдөр Мосе бутан дунд
гал асахыг харав. Гэвч бут
шатахгүй байв. Мосе юун гал
болохыг мэдэхээр ойртов.




Мосег бутанд дөхөн очтол Бурхан бутан дундаас түүнийг дуудав. "Мосе!" гэхэд Мосе "Би энд байна" гэв. Бурхан "Бүү ойрт" гээд, "Хөлөөсөө шаахайгаа тайл учир нь чиний зогсож байгаа газар ариун юм" гэлээ.



**Бурхан "Би өөрийн хүмүүсээ Египетээс гарган
авч ирүүлэхээр чамайг Фараонруу илгээх
болно" гэв. Гэвч Мосе
явахаас айжээ.**



**Тэгээд Бурхан Мосед агуу хүчээ харуулав.
Тэр Мосегийн тулж явсан
таягийг могой
болгон
хувиргав.**



**Мосе могойн сүүлнээс барих үед буцаад таяг болов.
Бурхан бас өөр тэмдэг үзүүлэв.**





**"Гараа өвөртөө хий" гэж Бурхан хэлэв. Мосе
хэлсэнчлэн хийв. Түүний гар нь уяман
өвчтэй болсон байв.**



**Тэр дахин гараа дахин өвөртөө хийхэд
гар нь эрүүл болсон байв.**



Гэсэн ч Мосе явахаас татгалзсаар байлаа. Тэр "Би сайн ярьж чаддаггүй шүү дээ" гэхэд Бурхан уурсан "Чамд Аарон гэдэг ах байдаг биз дээ тэр чиний өмнөөс яриг түүнд өөрийн үгээ хэл" гэв.



**Мосе Иетройнд буцан ирээд
өөрийн зүйлээ аван
Египетийг зорилоо.**



**Бурхан Мосег удирдан ах
Ааронтой нь уулан дээр
уулзуулав. Мосе Ааронд
Еврейчүүдийг Египетээс
гаргах Бурханы
төлөвлөгөөг
ярьж өгөв.**



**Тэд хамтдаа яван Еврейчүүдийн
ахлагч нарт энэ мэдээг хэлэв.**

**Мосе Бурханы үзүүлсэн
тэмдгийг Еврейчүүдийн
ахмадуудад үзүүлэхэд
тэд Бурхан тэдэнд
тусалж чадна
гэдгийг
ойлгожээ.**




Тэд хамтдаа Эзэнд
мөргөл үйлдэв.




Мосе Аарон хоёр зоригтойгоор
Фараоны өмнө очив. Тэд түүнд
"Бурхан миний хүмүүсийг явуул" гэж

ХЭЛҮҮЛЭВ
ГЭВ.



**Фараон "Би Израйлийг явуулахгүй"
гэж хариулав. Тэр Бурханы үгийг
дагасангүй.**



Бурхан Фараоны бодлыг өөрчлөхийн тулд агуу хүчээ хэрэглэх болно.



Хан хүү хоньчин болсон нь

Бурханы үг Библиээс авсан түүх

Египетээс гарсан нь 2-5

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130



Төгсөв



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.

Хэрвээ та энэ үнэнд итгэж байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө амьдрахад туслаач. Амен.

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай! Иохан 3:16

